



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ХАНХ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 05 сарын 13 өдөр

Дугаар А/29

Ханх сум

Г Дэд ажлын хэсэг томилох тухай Г

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйл 66.1, Монгол Улсын Засгийн газрын "Шинэ хоршоо хөдөлгөөн" өрнүүлэх тухай 2024 оны 166 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1."Шинэ хоршоо - Чинээлэг малчин" арга хэмжээний төлөвлөгөөг малчин өрхүүдэд таниулан сурталчлах, мэдээлэл өгөх, мал аж ахуйн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж байгаа хоршоодын үйл ажиллагааг идэвхжүүлэх, чадавхжуулах, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх үүрэг бүхий багт дэмжлэг үзүүлэх дэд ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

Б.Баттүвшин (Засаг даргын орлогч)

Гишүүдэд:

Б.Баасансүрэн (Засаг даргын Тамгын газрын дарга)

К.Одгэрэл (ИТХ-н нарийн бичгийн дарга)

Ш.Отгонжаргал (Тураг 1-р багийн Засаг дарга)

Б.Анхбаяр (Хороо 2-р багийн Засаг дарга)

Э.Мөнхжаргал (Турт 3-р багийн Засаг дарга)

Б.Бямбабаяр (Баясгалант 4-р багийн Засаг дарга)

Б.Мөнхтөр (Хэсгийн төлөөлөгч)

Эрүүл мэндийн төвийн дарга

Т.Нямцэцэг (Газрын даамал)

Р.Нэргүй (Улсын бүртгэгч)

М.Эрдэнэсүрэн (Хөдөлмөр халамжийн мэргэжилтэн)

Б.Гантулга (Нийгмийн бодлогын мэргэжилтэн)

Нарийн бичгийн дарга:

Ц.Саранцэцэг (Хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтэн)

2.Зөвлөн туслах баг удирдамжийн дагуу малчин өрх бүгд хүрч ажиллах тул тус Зөвлөн туслах багийн гишүүд болон дэд ажлын хэсгийн гишүүдийг сумын төвд түр байрлаж ажиллах өрөө тасалгаагаар хангах, малчидтай уулзалт хийх, хоноглох байршил, замын маршрут, хугацааг тодорхой тусгасан ажлын төлөвлөгөөг Зөвлөн туслах багтай зөвшилцөн боловсруулж ажилласугай.

3.Үйл ажиллагаанд оролцож байгаа бүх төрийн албан хаагчид эрүүл мэнд, халдвар хамгаалал, аюулгүй байдал, хэв журам, төрийн албаны ёс зүй болон холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам зааврыг мөрдсүгэй.

4.Сумын Засаг даргаас болон Дэд ажлын хэсгээс авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан, мэдээг Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газарт 2024 оны 06 дугаар 05-ны дотор цахимаар хүргүүлсүгэй.

5.Захирамжийн хэрэгжилтэд холбогдох хууль тогтоомжийн дагуу хяналт тавьж ажиллахыг Хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтэн (Ц.Саранцэцэг) -т үүрэг болгосугай.

ДАРГА

Л.ДАВААБАЯР



My doc-2024 Zahiramj

6707000098